



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

Нийслэлийн өдрөөр хотын аялал зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/883 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.5.3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд их дээд сургуулиудад элсэн суралцаж буй хөдөө орон нутгийн нэгдүгээр дамжааны оюутан, Монгол улсад буй гадаадын оюутнуудыг хамруулсан нийслэл хот, түүхэн барилга байгууламж, соёлын өвтэй танилцуулах аяллыг 2018 оны 10 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд зохион байгуулахыг Дотоодын аялал жуулчлал, бүтээгдэхүүний хөгжил хариуцсан мэргэжилтэн Б.Ишдорж-д даалгасугай.

2. “Хотын аялал” зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, бэлтгэл ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. “Хотын аялал” зохион байгуулахад шаардагдах төсөв болох 5,153,250 /таван сая нэг зуун тавин гурван мянга хоёр зуун тавин/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг нягтлан бодогч /Б.Батцоож/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТСҮХ

1150500273

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 10
сарын 16 өдрийн А/82 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284525 СБТ-8936 1118263502

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН 379 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХОТЫН АЯЛЛЫН УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Их дээд сургуульд элсэн суралцаж буй хөдөө орон нутгийн оюутан залууст Улаанбаатар хотын түүх, соёл, аялал жуулчлалын үзмэрүүдийг таниулах, хотын соёл, хотын иргэний талаарх ойлголтыг төлөвшүүлэх, нийслэл хотоороо бахархах ухамсар, ойлголтыг өгөхөд энэхүү аяллын зорилго оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

Их дээд сургуульд элсэн суралцаж хөдөө орон нутгийн нэгдүгээр дамжааны оюутан 200, Монголд сурч буй гадаадын 250 оюутан нийт 450 оюутан, Монголын оюутны холбооны төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл аялалд оролцоно.

ГУРАВ. АЯЛЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

“Сити тур” төслийн хотын аяллын 2 автобус үйлчилгээнд явж, төслийн 2 хөтөч тайлбарлагч оюутнуудад тайлбар мэдээлэл хүргэнэ. Хотын аяллыг 2018 оны 10-р сарын 23-27-ны өдрүүдэд зохион байгуулна. Аялал тус бүр 45 хүний бүрэлдэхүүнтэй байна. Нэг өдөрт 90 оюутан аялна, аялал 5 өдөр үргэлжлэнэ.

ДӨРӨВ. АЯЛЛЫН ХӨТӨЛБӨР

2018.10.16

Улаанбаатар хот

№	Цаг	Үзэх зүйлс
1	08:40	- Д.Сүхбаатарын талбайд цугларч аялал эхэлнэ
2	09:00 – 10:00	- Төв талбай, Д.Сүхбаатарын хөшөө, Чингисийн хөшөө, ойр орчмын барилга байгууламжийг танилцуулна.
3	10:00 – 11:00	- Үлэг гүрвэлийн төв музей үзнэ
4	11:00 – 12:00	- Гандантэгчинлэн хийдийн үйл ажиллагаатай танилцана
5	12:00 – 14:00	- Үдийн цайны цаг
6	14:00 – 15:00	- Чойжин Ламын Сүм музей үзнэ /Мягмар, Лхагва гарагт/ - Богд Хааны Ордон музей” үзнэ /Пүрэв, Баасан, Бямба гарагт/
7	15:00 – 16:00	- Улаанбаатар хотын музей үзнэ. Энд аялал өндөрлөнө

Нийслэлийн Аялал жуулчлалын
 газрын даргын 2018 оны 10
 сарын 16 өдрийн А/82 дугаар
 тушаалын хоёрдугаар хавсралт

5284525 СБТ 48976 1118263502

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН 379 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН
 ӨНГӨРҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
 ХОТЫН АЯЛЛЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2018.10.16

Улаанбаатар хот

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах ажилтан	Хамтрах байгууллага ажилтан
1	Аялал зохион байгуулах удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргана, төсөв батлуулна, холбогдох газруудад албан бичиг хүргэнэ, гэрээ хийнэ	2018.10.16 2018.10.27	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Ишдорж	Монголын Оюутны Холбоо
2	Их дээд сургуулиудын 450 оюутанг аялалд харуулна	2018.10.23	Монголын оюутны холбооны Нарийн бичгийн дарга Д.Үүрийнтуяа	Их дээд сургуулиуд
		2018.10.24		
		2018.10.25		
		2018.10.26		
		2018.10.27		
3	Хотын аяллын үеэр "Сити тур" төслийн танилцуулга нэвтрүүлэг бэлдэнэ	2018.10.23 2018.10.27	Сити тур төслийн хөтөч Т.Туул Ч.Цацрал	"Намир медиа" ХХК

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 10
сарын 16 өдрийн А/Б2 дугаар
тушаалын туравдугаар хавсралт

5284325 СБТ-8016 1118203562

АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

2018.10.16

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Цэвэр усны зардал	475 ш	350	166,250
2	Зураг угаалгах зардал	475 ш	2,000	950,000
3	Музей үзэх тасалбар	475 хүн	3,000	1,425,000
4	Өдрийн хоолны зардал	475 хүн	5,500	2,612,000
НИЙТ				5,153,250